

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 05

Чойбалсан хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
1. Монгол Улсын хууль					
1.1	№1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2021.07.02 №1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуульд “Энэ хуулийн 19¹ дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн, ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно” гэж заасан бөгөөд уг зохицуулалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. 2023 онд хуулийн энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэн тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний тэтгэмж авах эрх үүсч ирэх хүүхэд төрүүлсэн эхэд амаржсаны тэтгэмж олгох хугацааг 80 хоногоор, уг хоногт ногдох амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцон олгож байна. Дорнод аймгийн хэмжээнд тайлант онд ихэр хүүхэд төрүүлсэн нийт 3 даатгуулагч эхэд 3204.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна		
1.2		Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.22	Хууль тогтоомжийн дагуу дараах урсгал үйл ажиллагааны зардлуудыг хэмнэн ажиллалаа. Үүнд: - Байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардалд 13,671.8 мянган төгрөг батлагдсанаас 11,565.8 мянган төгрөгийг зарцуулж 2,106.0 мянган төгрөгөөр, - Бичиг хэргийн зардалд 6,417.3 мянган төгрөг батлагдсанаас 5,830.4 мянган төгрөгийг зарцуулж 586.9 мянган төгрөгөөр хэмнээд байна. Нийт албан хаагчид байгууллагын дотоод албан бичиг, албан хэрэг хөтлөлтийн able программ болон		

			<p>дотоод сүлжээнд цахимаар дамжуулан ашиглаж, бичиг хэргийн материал, бичгийн цаас, принтерийн хорыг хэмнэн ажилласан байна.</p> <p>-Нийгмийн даатгалын байгууллага нь суудлын автомашин ашиглахыг хориглосон тул жолоочийн цалин хөлс, шатахуун, засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг гаргалгүй 6,042.2 мянган төгрөгөөр шатахууны зардлыг хэмнэсэн.</p> <p>-Сумдын байцаагч нарыг “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, байцаагч, ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, харилцаа, хандлага, сэтгэлгээг өөрчлөх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах” сургалт, газар дээрх хяналт шалгалтыг шаардлагатай тохиолдлоор зохион байгуулахад тус тус томилолтыг зарцуулж, 607.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.</p>		
1.3		<p>Засгийн газрын 238,239 дүгээр тогтоол</p> <p>2023.07.01-ээс</p>	<p>Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг 14281 иргэний тэтгэвэр тогтоолгосон дундаж цалинг итгэлцүүрээр шинэчлэн тогтоох ажлыг хийж гүйцэтгэн бүрэн тэтгэврийн доод хэмжээг 550000 төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээг 440000 төгрөгөөр тогтоон, тогтоолтын хуудсыг хэвлэж баталгаажуулан ажилласан. Мөн Засгийн газрын тогтоолоор итгэлцүүр хэрэглэн шинэчлэн тогтоогдсон тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэн тооцож 7 дугаар сарын 1-ний өдрөөс иргэдэд өөрчлөгдсөн тэтгэврийг олгож эхэлсэн болно.Тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэн тооцож олгоход тэтгэврийн даатгалын сангийн зардал өмнөх сарын дүнгээс 1.461.091,1 мянган төгрөгөөр өссөн ба жилийн дүнгээр 8.966.546,8 мянган төгрөгөөр зардал нэмэгдсэн болно.</p>		
1.4		<p>“Нийгмийн даатгалын багц хууль” /Шинэчилсэн найруулга/</p> <p>2023.07.07</p>	<p>УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль шинэчилсэн найруулга батлагдсан. Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах талаар НДЕГ-аас нийт ажилтнууд болон ажил олгогч, даатгуулагчдад сургалт зохион байгууллаа. Мөн хууль тогтоомжийн өөрчлөлтийг иргэд даатгуулагчдад сурталчлах 4 байцаагчийг сургагч багшаар бэлтгэн сертификат олгосон. Хуулийн шинэчилсэн найруулгын талаар орон нутгийн телевизүүд, нийгмийн сүлжээнд мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”, сумдын “Малчдын зөвлөгөөн”, “Нийгмийн цогц үйлчилгээ”-ний хүрээнд болон ажил олгогч даатгуулагчдад 22 удаагийн сургалтаар 1822 гаруй даатгуулагчдад мэдээлэл хүргээд байна. Нийгмийн</p>		

			даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд тэтгэвэр бодох дараалсан 7 жилийг 5 жилийн цалингаар тогтохтой холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс өмнө тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлтийг хүлээн авч эхлээд байна.		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					
2. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар					
2.1	№03	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022.07.04 №03	<p>Нийгмийн даатгалын байгууллага нь эрэлт ихтэй үйлчилгээг операторын горимд шилжүүлэх, газарзүйн байршлаас үл хамааран төрийн үйлчилгээг цахимаар шуурхай хүргэх зорилгоор 2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын 17 төрлийн үйлчилгээг цахимжуулаад байна. Цаашид төрийн байгууллагууд хооронд интеграци хийх, цогц нэгдсэн байдлаар үйлчилгээ үзүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын мэдээллийн систем 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс веб-д суурилсан кор системд шилжихтэй холбогдуулан ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийг шинэчлэн, алдаатай мэдээллийг залруулах ажлыг зохон байгуулж, шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн 301 ажил олгогчийн мэдээллийн баазын бүртгэлд хяналт хийж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил олгогчийн улсын бүртгэлийн хаяг өөрчлөгдсөн - 1 • Байгууллагын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн - 0 • Байгууллагын захирал /эзэн холбогдогч/, нягтлан бодогч нь өөрчлөгдсөн - 12 • Үйл ажиллагаагаа зогсоосон – 25 • байгууллагын нөхцөл байдлыг судалж, мэдээллийн баазыг шинэчлэн ажиллалаа. <p>Мөн даатгуулагчийн овог нэр өөрчилсөн 6, регистрийн дугаар өөрчлөгдсөн 4 мэдээллийг хүлээн авч http://10.9.0.5/regweb/ цахим мэдээллийн сангаас тулган баталгаажуулж мэдээллийг засварласан. Тайлант онд даатгуулагчийн ID давхардсан 104 даатгуулагчийн мэдээллийг нэгтгэж мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг ханган ажиллалаа.</p> <p>Түүнчлэн тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлыг эхлүүлж, энэхүү ажлын хүрээнд нийт 14500 тэтгэвэр авагчдын хувийн хэргийг метадата хэлбэрт оруулаад байгаа бөгөөд цаашид программ хангамжийн тусламтайгаар өдөр тутмын болон хяналт шалгалтын ажилд ашиглах шаардлагатай байна.</p>		

Хавсралт: Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд
цахимаар үзүүлж буй үйлчилгээ

3. Засгийн газрын тогтоол

3.1.	№362	<p>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам</p> <p>2021.12.01 №362</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 362 дугаар тогтоолоор “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсан. Уг журмаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.2[1], 13.1.5-д зааснаас бусад нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж (цаашид “тэтгэвэр, тэтгэмж”гэх)-ийн хугацаа, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд 6 дугаар зүйлд “нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн” талаар зохицуулсан байна.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэвэр авагч “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2 хэсэгт заасны дагуу шимтгэл төлж, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан тэтгэвэр авах нөхцлийн хангасан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоон олгож байна.</p> <p>Дорнод аймагт 2022 онд нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 38 иргэн дээрх нөхцлийн ханган нийгмийн даатгалын сангаас хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгож, нийт 152.0 сая төгрөг зарцуулсан байна.</p>		
3.2.	№7	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>2022.01.05 №7</p>	<p>Тус хэлтэс нь нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтнүүдийн хэрэгжүүлж буй хууль, эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг сайжруулах арга хэмжээ авах талаар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд жил бүр тусган баталж, гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт ажилтнуудыг Монгол бичгийн мэдлэгийн түвшин тодорхойлж НДЕГ-аас зохион байгуулж буй “Монгол бичгийн анхан болон дунд шат”-ны сургалтад цахимаар сургаж эхлээд байна.</p> <p>Сургалтад нийт 34 байцаагч, ажилтнуудыг хамруулсан. Түүнчлэн төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх зорилтын хүрээнд хэлтсийн гаднах хананд “Нийгмийн даатгал – Таны амьдралын баталгаа” уриа үгийг үндэсний бичгээр бичиж байршуулсан.</p>		

3.3.	№479	<p>Хяналт шалгалт хийх нийтлэг журам</p> <p>2022.12.28 №479</p>	<p>Хяналт шалгалт хийх нийтлэг журмын баримтлан хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт 7, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1, Цахим мэдээлэлд тулгуурласан хяналт шалгалтуудыг тус тус хийж гүйцэтгэв.</p> <p>“Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 2023 онд хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 3 шалгуур үзүүлэлтээр 22 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт, шалгалтыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу уул уурхай болон газрын тосны 11, Барилга угсралтын чиглэлийн 4, Зам тээрийн чиглэлийн 4, Боловсролын 1, Эрчим хүчний салбар 1, бусад 1 хамруулав.</p> <p>Шалгалтаар ажилласан жилийг буруу тооцсон улирлын шинж чанартай ажил гүйцэтгэдэг бөгөөд тодорхой ажилчдын ажиллаагүй байх хугацааны НДШ тооцоогүй, /тухай ажилчид эргэж ажилдаа ороогүй/ Ахмадын сан байгуулаагүй дэмжлэг тусалцаа үзүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаагүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг байна. Иймд илэрсэн зөрчил дутагдал заавар зөвлөмж өгч улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулан хяналтын хуудсаар эрсдэлийг тооцож ажиллалаа. Нийт 22 ААНБ-ын мэдээллийг хавсралт хүснэгтээр болон тус бүрийн удирдамжийн хүрээнд тус бүр нь тайлагнаж ирсэн. Салбар бүрийн дундаж эрсдэлийг тооцоход МСҮТ 3.7, Барилга 42.5, уул уурхай 23.9, зам тээвэр 31.2, эрчим хүч 38.5 хувьтай үнэлэгдсэн.</p> <p>“Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 2.7-д заасны дагуу 2023 онд хийсэн объектын эрсдэлийн үнэлгээг үндэслэн Барилга, Уул уурхай, Зам тээвэр, Хөдөө аж ахуй, Худалдаа гэсэн 5 чиглэлээр Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчтай хамтран 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 16 байгууллагын жагсаалтын төслийг хуульд заасан хугацаанд хүргүүлэв.</p>		
3.4.	№187	<p>Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах хэмжээний тухай</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллахыг үүрэг болгосны дагуу тус хэлтсээс ажил олгогч, иргэд, даатгуулагчдад үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээ, хэлтсийн болон байцаагч ажилтнуудын үйл ажиллагаа, харилцаа хадлагатай холбоотой санал хүсэлтийг бичгээр болон хэлтсийн лавлах утас (70585955), цахим (вэбсайт,</p>		

		2022.05.11. №187	<p><i>фейсбүүк пэйж, чатбот</i>) хэлбэрээр хүлээн авч, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний чанар, ажилтнуудын харилцааны талаарх мэдээлийг 7058-5955 утсаар хүлээн авч 2023 оны байдлаар 3574 дуудлага ирсэн байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Сайн дурын даатгалтай холбоотой 27% - Эрүүл мэндийн даатгалын тухай 14% - Шимтгэлийн буцаан олголтын талаар 15% - Тэтгэврийн тогтоолт, олголттой холбоотой 7% - Тэтгэмжийн тогтоолт олголттой холбоотой 28% - Бусад 9 хувийг эзэлж байна. 		
3.5.	№204	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.25 №204	Төрийн хэмнэлтийн хуулиар батлагдсан автомашиныг хэрэглээг хуулиар хязгаарлах болсонтой холбогдуулан тус хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12-89 ДОО дугаартай Форд эверест маркийн тээврийн хэрэгслийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэлтсийн албан хэрэгцээнд ашиглаагүй болно Үүнтэй холбогдуулан жолоочийн цалин, орон тоо 9000.0 мянган төгрөгөөр хэмнэгдэж, тээвэр шатахууны зардал 6042.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн үзүүлэлттэй байна.		
3.6.	№500	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2023 оны хувь хэмжээг тогтоох тухай 2022.12.28 №500	<p>Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, төлөвлөгөө хуваарийн дагуу 9147880,2 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 9409262,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 102,9 хувиар биелүүлэн ажиллаа. Үүнээс ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл 8792034,4 мянган төгрөг, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн 615465,6 мянган төгрөгийн шимтгэл санд төвлөрсөн байна.</p> <p>Эрүүл мэндийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоног бүрийн сүүлийн өдөр эрүүл мэндийн даатгалын сангийн дансны үлдэгдлийг НДЕГ-ийн эрүүл мэндийн орлогын дансанд төвлөрүүлэн ажилласан. Энэ онд нийт 9373111.6 мянган төгрөгийн эрүүл мэндийн даатгалын хураамжийг төвлөрүүлсэн байна.</p> <p>Аймгийн 2023 оны жилийн эцсийн байдлаар оюутан 612, малчин 1235, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 5955, бүгд 7802 даатгуулагч, иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.</p>		

			<p>Эрүүл мэндийн даатгалын санд оюутан 402.93,1 мянган төгрөг, малчин 128699,8 мянган төгрөг, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэнээс 446.472,7 мянган төгрөг ба нийт 615465,6 мянган төгрөгийн хураамжийг төвлөрүүлж ажиллалаа.</p> <p>Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж буй иргэд, даатгуулагчид интернэт, мобайл банк, И-баримт ашиглан эрүүл мэндийн даатгалын хураамжаа төлж байгаа ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай хүртэхийн тулд Е-баримтын цахим үйлчилгээг 100 хувь бүрэн ашиглаж сурсан байна.</p>		
3.7.	№49	<p>2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай</p> <p>2023.02.08 №49</p>	<p>Иргэд, даатгуулагчдад хэлтсийн вэб сайт, фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд зориулсан постер зураг, шторкыг түгээхээс гадна хэлтсийн үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэн ажиллаж хэвшсэн болно.</p> <p>Мөн тус хэлтсээр үйлчлүүлж буй иргэд даатгуулагчдаас нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний чанар болон нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэл үр дүнг Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт хүргүүлсэн байна.</p> <p>Хэлтсийн албан ёсны цахим фэйсбүүк хаяг болон мэдээллийн самбарт өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, шударга байдлыг уриалсан агуулга бүхий “Нийгмийн даатгал- Авлигагүй бүс” зурагт хуудас болон авлигын талаарх мэдээллийг 110 дугаарт үнэ төлбөргүй өгөх зэрэг холбогдох мэдүүлүүдийг тус тус байршуулж олон нийтэд иргэд даатгуулагчдад хүргэсэн. Авлигатай тэмцэх газар болон Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны нэг арга хэмжээ болох “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аяны сурталчилгааны постер, шторкийг өөрийн байгууллагын олон нийтийн цахим фэйсбүүк хаяг, мэдээллийн самбарт байршуулж иргэд, даатгуулагчдад түгээн ажилласан.</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 9 албан хаагчдын хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдүүлгийг хуулийн хугацаанд холбогдох материалын хамт мэдээллийг илгээж, Авлигатай тэмцэх газарт хянуулан, 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хянаж бүртгэсэн байна.</p>		

			2022 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах ТЗ-6 болон түүнээс дээш ангилал, зэрэглэлд ажилладаг 17 албан тушаалтнаас ХАСХОМ-ийг цахимаар авч, баталгаажилтын хуудсаар бүртгэл хөтлөн ХОМ-1, ХОМ-3, ХОМ-4 тайлангуудыг нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.		
3.8	№60	Журам шинэчлэн батлах тухай 2023.02.08 №60	Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан ажил олгогч даатгуулагчдад 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 60 дугаар тогтоолыг танилцуулсан байна. Тогтоол шинэчлэгдсэнтэй холбогдуулан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны НДШ төлөх журам”-д гарсан өөрчлөлтийг сурталчлан ажиллалаа. Аймгийн хэмжээнд ажил олгогчоос хуулийн дагуу шимтгэл төлж байгаа “06” кодтой - 878 даатгуулагч, “17” кодтой - 460 даатгуулагч, “25” кодтой - 339 даатгуулагч, “21” кодтой - 108 даатгуулагч, “20” кодтой - 8 даатгуулагч, “28” кодтой - 2 даатгуулагч, “38” кодтой - 4 даатгуулагч, “39” кодтой – 3 буюу нийт 1802 даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.		
3.9	№487	“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022.12.28	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” №487 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хэлтсийн нийт байцаагч ажилтнуудын ангилал, зэрэглэл, албан тушаалын шинэчлэлийг ТАЗ-ийн ХНУМТ, Green ERP програмууд дээр мэдээллийг шинэчлэн бүртгэж хэлтсийн даргын 2023 оны Б/01 дүгээр тушаал болон холбогдох мэдээллийг байршуулж төрийн албан хаагчийн хувийн хэрэгт ажилтан тус бүрээр баяжуулалт хийж ажиллалаа.		
3.10	№488	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” №488 дугаар тогтоолын хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хэлтсийн нийт 37 байцаагч ажилтнуудын цалинг		

		хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” /2-р хавсралт/ 2022.12.28.	шинэчлэн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны Б/01 дүгээр тушаал гаргаж ТАЗ-ийн ХНУМТ, <i>Green ERP</i> программууд дээр мэдээллийг шинэчлэн бүртгэж цалингийн мэдээллийг байршуулж төрийн албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийлээ.		
3.11	№489	“Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” /4 дэх хэсэг/ 2022.12.28.	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” №489 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт баталсан орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар тооцон аймаг, сумын байцаагчдад тооцон олгох, хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хэлтсийн нийт 31 ажилтны цалинг шинэчлэн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаал гаргаж ТАЗ-ийн <i>ХНУМТ</i> программд мэдээллийг бүртгэж ажиллалаа		
3.12	№491	“Журамд өөрчлөлт оруулах тухай” 2022.12.28.	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” №491 дүгээр тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хэлтсийн даргын 2023 оны Б/02 дугаар тушаалаар нийт 36 ажилтнаар шинэчлэн тогтоож, ТАЗ-ийн <i>ХНУМТ</i> программд мэдээллийг бүртгэн, ТАХ-ийн хувийн хэргийн баяжилтыг хийлээ.		
3.13	№98	“Аргачлал, загвар батлах тухай” 2023.10.31	Хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/11 тоот тушаалаар “Үнэлгээний баг” байгуулж хэлтсийн болон ажилчдын гүйцэтгэлийн тайлан мэдээг хавсралт маягтын дагуу тайлагнаж ирүүлэх зөвлөмжийг өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээг өгч ажиллаж байна.		
3.14	№362	“Дүрэм батлах тухай” 2023.10.13	ЗГ-ын 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан “ <i>Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм</i> ”-ийг нийт ажилтнууд болон, даатгуулагч тэтгэвэр авагчдад мэдээлэн ажиллаж байна. Шинэ дүрмийн дагуу салбар зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах ба нутгийн захиргааны байгууллага болон ажил олгогч, даатгуулагчийн төлөөлөл оролцоно. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг салбар зөвлөлийн дарга томилохоор зохицуулсан байна.		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					

4. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

4.1.	№28	<p>Тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах</p> <p>2022.05.11 №28</p>	<p>Цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох бусад тогтоол, журмын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын албан хаагчдын үйл ажиллагаанд цахим гарын үсгийг нэвтрүүлэх, түүнийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Дээрх ажлын хүрээнд тоон гарын үсэг эзэмших албан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, зөвлөгөө өгөх үүрэг бүхий тоон гарын үсэг хариуцсан бүртгэлийн ажилтныг хэлтсийн даргын тушаалаар томилсон.</p> <p>Бүртгэлийн ажилтан нийгмийн даатгалын хэлтсийн 33 тоон гарын үсэг эзэмших албан хаагчдын мэдээллийг бүрдүүлж и-токен төхөөрөмжийг “Үндэсний дата төв”-д хүргүүлэн, ESIGN программд албан хаагчдын тоон гарын үсгийг бүртгүүлж бэлэн байдлыг ханган ажиллаа.</p>		
4.2.	№64	<p>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 50 хувиар бууруулах</p> <p>2022.12.14 №64</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021.12.14-ний №64 дүгээр шийдвэрийн дагуу цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулан ажиллав.</p> <p>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2023 оны 03 сарын 03-ны өдрийн 06/428 тоот “Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж”-ийн дагуу Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд, мөн Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч байгаа эсэхийг шалгав.</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “Халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” Монгол улсын засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 362 тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хугацаа, олгох журам”-ын 6.1.2-д “нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн” бол тэтгэврийг зогсоох гэсэн заалтуудыг тус тус зөрчиж Нийгмийн халамжаас болон нийгмийн даатгалын сангаас тэтгэврийг давхардуулан авсан байна.</p> <p>Хяналт шалгалтаар Нийгмийн Халамжийн сангаас ирүүлсэн өндөр нас, тахир дутуу, тэжээгчээ алдсан, одой нийт 1552 иргэдийн нэрсийг нэг бүрчлэн Нийгмийн даатгалын 14178 иргэдийн жагсаалттай нэг бүрчлэн тулгаж 230 иргэний давхардлыг илрүүлж ажилласан. Үүнээс өндөр насны болон тахир дутуугийн 31 иргэний тэтгэвэр давхардаж 8,2 сая төгрөгийн зөрчлийн халамжийн санд төвлөрүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож ажиллалаа.</p>		

-Хэрлэн сумын хэмжээнд 1794 иргэн 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх эцгийг нэг бүрчлэн Нийгмийн даатгалын хэлтэст *ndlaw* программд тулгалт хийж давхардлыг гаргаж ирсэн. Энэ нь тухай эх хүүхдээ харж байх хугацаандаа урамшуулал орсон тохиолдолд 68 кодтой байх бөгөөд ААНБ нь ажилд орсон эхийг 68 кодоор оруулж давхардал үүсгэсэн байна. Мөн ХБИргэн 70 кодтой тул халамжийн программ хүлээж авч зогсоогддоггүй байна.

- Тусгай зөвшөөрөлтэй ААН нэгжийн үйлчилгээний чанар муудсан. Жишээлбэл сонсголын аппарат тусгай хэрэгсэл тоног төхөөрөмж чанаргүйжсэн.
- Төсөл зээл хүрэх эзэндээ хүрдэггүй
- ӨН тэтгэвэр 4, ХБ 3, ТА 1, байнгын аасаргаа 1, бүтэн өнчин хүүхдийн асаргаа 1 анхан шатны бүрдэл болох хувийн хэрэг байхгүй зөрчлийн ХБ зөрчил арилсан бусад зөрчлүүд арилаагүй, хаяг утсандаа байхгүй иргэд байна.
- Удирдах дээд байгууллагын дотоод хяналт шалтгалтын зохион байгуулалт төлөвлөлт хангалтгүй.
- Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрээр түүвэрчлэн очиж тусгай хэрэгсэл үзэхэд хүүхдийн хөлний согог засах гутал шаардлага хангахгүй энгийн гутал олгосон, суултуур шаардлага хангахгүй, тэргэнцэрээ хэрэглээгүй 2 жил болсон, бүс болоод бусад хэрэгслийг бусдад өгсөн шилжүүлсэн зэрэг зөрчлүүд байна.
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал бага, нийгмийн даатгал тооцдоггүй.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж цалинтай ээжийн ажилдаа орчоод халамжийн сангаас давхардаж авсан 6,2 сая төгрөгийг буцаан санд төвлөрүүлэх үүрэг өгч ажиллалаа.

-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлууд нь зориулалт бусаар ашигласан хуурамч баримт бүрдүүлсэн байх магадлал, төсөл хөтөлбөрүүд эзэн холбогчдооо хүрээгүй, баримтгүй гүйлгээ гарсан, нэг байгууллагад давуу эрх олгож олон төрлийн дэмжлэгүүдийг олгосон, цар тахлыг далимдуулж хэрэгслүүд авсан гэх боловч тодорхойгүй, хөтөлбөр төсөлд зориулсан гэх бензин бичиг хэргийн зардлууд их зарцуулагдсан, хүний бичиг баримтыг ашигласан, өнгөрсөн оны баримт хуулбарлаж бүрдүүлсэн, танил тал найз нөхдийг хамруулсан, хүний лангуу дэлгүүр үзүүлж эргэн төлөгдөх чадваргүй хүнд олгож өр үүсгэсэн, хөтөлбөр төсөлд хамрагдсан иргэнээс 50 хувь буцаан авсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

			<p>Дээрх зөрчил дутагдлууд болоод өмнөх онуудын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд байгууллагын зүгээс авсан арга хэмжээ байхгүй байна.</p> <p>Иймд ашиглал, зориулалт бусаар үйлдсэн зөрчлийг дахин давтагдуулахгүй байхын тулд, төсвийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулж ажиллуулахын тулд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 392 албан тоот бичгээр Цагдаагийн байгууллагад хүргүүлж шилжүүллээ.</p> <p>-Хяналт шалгалт хийх явцад зөрчлийн шинжтэй 6 үйлдэлд Зөрчлийн тухай хуульд заасан гомдол мэдээллийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байсан тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргасан.</p> <p>Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдолд үндэслэн 90 байгууллага, иргэнд Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 83,4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж 31,7 сая төгрөгийн алданги, 9,0 сая төгрөгийн торгууль тооцож бүрэн барагдуулав.</p> <p>Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн зөрчлийн талаарх судалгаа, тоон мэдээлэл, тайланг хагас, бүтэн жилээр Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн ажиллав.</p> <p>- Төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтаар 2022 оны тэтгэврийн олголт, шилжилт хөдөлгөөн, нас баралтад шалгалт хийж 23 хүнд холбогдох 6,4 сая төгрөгийн илүү олголт, 18 хүнд холбогдох 5,3 сая төгрөгийн дутуу олголтыг илрүүлэн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулаад байна.</p>		
4.3.	№11	<p>Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх...</p> <p>2022.02.16 №11</p>	<p>Монгол Улсын Их Хурлаас "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг баталсан. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэхээр тусгасан бөгөөд зургаа дахь багц асуудал (Төрийн бүтээмжийн сэргэлт)-д төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, төрийн хүнд суртлыг бууруулах ажлын хүрээнд нийгмийн даатгалын байгууллага нь эрэлт ихтэй үйлчилгээг операторын горимд шилжүүлэх, газарзүйн байршлаас үл хамааран төрийн үйлчилгээг цахимаар шуурхай хүргэх зорилгоор 2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын 17 төрлийн үйлчилгээг цахимжуулаад байна. Цаашид төрийн байгууллагууд хооронд интеграци</p>		

			хийх, цогц нэгдсэн байдлаар үйлчилгээ үзүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.		
4.4.	№41	МУ Засгийн газрын хурлын тэмдэглэл 2022.08.17 №41	Дорнод аймгийн Нийгмийн даатаглын хэлтэс нь иргэдийн гомдол, өргөдлийг биечлэн, цахим сүлжээгээр, байгууллагын албан ёсны цахим шуудан, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв, аймаг, хэлтэст ашиглаж буй тусгай дугааруудаар хүлээн авч байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23.3-т “иргэн, хуулийн этгээдэд иргэний хуулийн этгээдийн бүртгэлийн дугаараар үндэсний цахим шуудангийн хаягийг үүсгэнэ” гэж заасан бөгөөд Монгол Улсын үндэсний цахим шуудангийн системийг нэвтрүүлж, 16 наснаас дээш иргэд “И-Монголиа” системээр дамжуулан и-мэйл хаягтай болж байна.		
4.5.	№46	МУ Засгийн газрын хурлын тэмдэглэл 2022.09.22 №46	Өнөөдрийн байдлаар танилт, нэвтрэлтийн системд бүртгэлтэй иргэн тус системийг ашиглан төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг төрийн үйлчилгээний нэгдсэн “E-Mongolia” системээр дамжуулан хүргэх, иргэнийг таньж баталгаажуулсан үндэсний цахим шуудангийн хаягаас өргөдөл, гомдол хүлээн авах, хариу хүргүүлэх боломж бүрдэж, иргэд төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргахдаа заавал биечлэн эсхүл утсаар өгдөг байсан бол энэхүү системээр дамжуулан төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах, хариуг хүлээн авах боломжтой болсон.		

Хэрэгжилт: 100 хувь

5. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал

5.1.	№A/191	Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам 2021.12.06 №A/191	Хэлтсийн даргын 2023 оны Б/08 дугаар тушаалаар 36 байцаагч, ажилтнуудын 2023 оны ээлжийн амралтын хуваарь, амралтын хоног батлагдсаны дагуу ээлжийн амралтын цалинг сүүлийн 12 сарын цалин хөлсний дунджаар нийт ажилласан өдөрт хувааж, амралтын хоногоор бодон олгож байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр ээлжийн амралтын цалинг тооцож, сар дамнасан ээлжийн амралтыг 2 хуваан бодсон байна. Жирэмсний болон амаржсаны амралттай байсан 1 ажилтанд ээлжийн амралт, 3 албан хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тул ээлжийн амралтын тооцоог өмнө амарсан хугацаанаас эхлэн амралтын хоногийн зөрүүг бодож, ээлжийн амралтын цалинг олгосон байна.		
5.2.	№A/192	Дундаж цалин хөлс тодорхойлох журам	“Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын талаар хэлтсийн ажилтан албан хаагчдын “Шуурхай хуралдаан”-д нийт ажилтнуудад танилцуулж ажиллалаа. Тайлант хугацаанд 1 ажилтны жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг бодохдоо сүүлийн 12 сарын ажилласан хугацааны дундаж цалин хөлсний нийлбэрээр		

		2021.12.06 №А/192	тооцоолж, хөдөлмөрийн чадвараа түр алдсан 5 байцаагч, ажилтны тэтгэмжийг сүүлийн 3 сарын дундаж цалин хөлсөөр, 38 байцаагч, ажилтнуудын ээлжийн амралтын цалин хөлсийг тус тус дундаж цалин хөлс тооцоолох журмын дагуу бодсон байна		
5.3.	№А/193	Ажлын цагийг нэгтгэн бодох журам 2021.12.06 №А/193	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой “Ажлын цагийг нэгтгэн бодох журам” өөрчлөгдсөнийг хэлтсийн байцаагч, ажилтнуудад танилцуулсан.		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					
6. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал					
6.1.	№А/01	Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн доор болон хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023.01.02 №А/01	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн доор болон хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” жагсаалтад өөрчлөлт орсон. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажил, мэргэжлийн нэрийг уг жагсаалттай нийцүүлэн холбогдох тушаал, шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэрт тодорхой бичиж байхыг аж ахуйн нэгж, байгууллагад даалгасан байх тул цаашид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт” болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад нийцүүлэн ажилд томилох, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ хийх зэрэгт тусган ажиллах талаар Дорнод гурил ХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ зэрэг газруудад зөвлөмж хүргүүлсэн		
6.2	№А/06	Мэргэшлийн зэрэг олгох тухай 2023.01.19 №А/06	Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрэм”-д заасны дагуу мэргэшлийн зэрэг авсан 19 албан хаагчдад үндсэн цалингийн 10 хувиар 10,679.4 мянган төгрөгийг олгоод байна.		

Хэрэгжилт: 100 хувь

7. Сангийн сайдын тушаал

7.1	№65	Хөтөлбөр батлах тухай 2023.03.29 №65	Нийгмийн даатгалын санхүүгийн тайланг “төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, УСНББОУ Стандарт, бусад хууль тогтоомжид үндэслэн бэлтгэж тайлагнаж байна. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл нь анхан шатны баримтаар нотлогдсон хууль тогтоомжид үндэслэсэн ажил гүйлгээг бүртгэж журналын бичилт болон холбогдох бичилтүүдийг хийж санхүүгийн тайлан бэлтгэж байна. Цаашид нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, нийгмийн даатгалын мэдээллийн системийн шинэчлэлтэй холбогдуулан нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна.		
-----	-----	---	--	--	--

Хэрэгжилт: 100 хувь

8. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын тушаал

8.1	№А/23	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2023.03.20 №А/23	Байгууллагын 2022 оны эд хөрөнгийн улсын тооллогын төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтууд /ТӨХ1, ТӨХ2, ТӨХ3, ТӨХ4, ТӨХ5, ТӨХ6, ТӨХ7, ТӨХ11, ТӨ3/, санхүү байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээ, тайланг pdf хэлбэрээр тус тус ТӨБЗГ-ын www.burtgel.pcsp.gov.mn тооллогын программд 2023 оны 4 дүгээр 18-ны өдрийн дотор оруулж, баталгаажуулан цаг хугацаанд нь илгээсэн. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулж эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эд хариуцагч бүрийн хөрөнгө ашиглалтад хяналт тавьж ажилласан. Байцаагч, ажилтан бүрийн эд хөрөнгийн картад бүртгэлтэй хөрөнгө тус бүрийг программын хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган, ашиглалт, хадгалалт, шилжилт хөдөлгөөн, хамгаалалтын байдалд хяналт тавин ажилласан байна.		
-----	-------	--	---	--	--

Хэрэгжилт: 100 хувь

9. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол

9.1	№07	Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай 2022.12.28 №07	Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод хүү тооцсон тухай мэдээллийг хэлтсийн албан хаагчдын хуралд танилцуулж ажиллалаа. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой ажил олгогч даатгуулагчдад зориулсан сургалтыг үе шаттайгаар хийж байна. Дээрх сургалтад оролцсон 117 аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч санхүүгийн ажилтнууд, 446 албан хаагчдад нэрийн дансны тухай мэдээлэл түүнийг хаанаас хэрхэн харж ашиглах талаар заавар зөвлөгөө өгсөн болно.		
9.2	№06	2023 оны төсвийн хуваарь батлах тухай 2022.12.28 №06	Нийгмийн даатгалын сангийн 2023 оны батлагдсан төлөвлөгөөний нийт орлого 46,348.4 сая төгрөг, зарлага 99,228.8 сая төгрөгийг сум, ажил олгогчийг хариуцан ажиллаж байгаа байцаагч тус бүрээр сар, улирлын нарийвчилсан хуваарилалтыг хийсэн. Нийт албан хаагчдад нийгмийн даатгалын сангийн 2023 оны орлого, зарлага, эрүүл мэндийн даатгалын орлогын хуваарилалт, өмнөх оны төлөвлөгөөний биелэлтийг харьцуулсан график, хүснэгтээр танилцуулж, мэдээллээр хангасан. Төлөвлөгөөний хуваарилалтыг хэлтсийн даргаар батлуулж, 13 сумдын байцаагч нарт нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, шимтгэлийн авлагыг бууруулахад анхаарч сумын Засаг даргатай хамтарч ажиллах чиглэлээр хэлтсийн албан даалгавар гаргаж хүргүүлсэн.		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					
10. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
10.1	№A/193	Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах, шилжүүлэх, ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай 2022.12.30 №A/193	ТӨБЗГ-ын 2022 оны “Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 695 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалын дагуу тус хэлтэст бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, цаашид ашиглах боломжгүй болсон 11 төрлийн 53,046.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3 төрлийн 2,810.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлын хөрөнгийг тус тус актлах, тус хэлтсийн хөрөнгөд бүртгэлтэй боловч Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст ашиглагдаж байгаа 6,486.8 мянган төгрөгийн өртөгтэй, 4,486.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 2,000.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй архивын сканнерыг шилжүүлж данс бүртгэлээс хассан байна.		
10.2	№A/194	Тоног төхөөрөмж, программ хангамж хуваарилах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар компьютер тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл хуваарилалтын дагуу суурин компьютер /dell optiplex 3090/ 15 ширхэг 22,433.4 мянган төгрөг, дэлгэц /dellE2222H monitor/		

		2022.12.30 №А/194	15 ширхэг 7,022.4, тог баригч 15 ширхэг 3,834.6 мянган төгрөг, зөөврийн компьютер 6 ширхэг 12 003.6 мянган төгрөг нийт 45,294.0 мянган төгрөгийн хөрөнгийг байцаагч нарт хуваарилан санхүүгийн GreenErp программын машин тоног төхөөрөмж болон эд хөрөнгийн картад бүртгэсэн.		
10.3	№А/145	Нийгмийн даатгалын салбарын хүүхэд хамгааллын бодлого батлах тухай 2022.10.03 №А/145	Тус хэлтсийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл” нь хүүхэд хамгааллын бодлогын дагуу 2023 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэлтсийн даргаар батлуулан дараах ажлуудыг хийж байна. Үүнд: - Хэлтсийн ажилтан албан хаагчдын хүүхдийн судалгааг нас тус бүрээр ангилан судалгаа гаргаж эрсдэлийн үнэлгээ хийсэн, мөн мэдээллийн бүрдлийг тухай бүр шинэчилсэн. - Ажилтнуудын Баасан гаригийн “Шуурхай хуралдаан”д хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга барилын талаарх сургалтыг Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын мэргэжилтэнтэй, мөн хэлтсийн нийт албан хаагчдын сургалтад “Шинэ эрин чадамжийн төв”-тэй хамтран харилцаа хандлага сэтгэлгээг өөрчлөх сургалтуудыг хийсэн, - Ажилтан албан хаагчдад хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм танилцуулж гэрээ байгуулсан, шинээр орж буй ажилтанд мөн адил, - Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх хүүхдийн амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх чиглэлээр “Хүүхдийн өрөө” байгуулах ажлыг хийж байна. Цаашид бага насны хүүхэдтэй ялангуяа өрх толгойлсон ажилтнуудын ажиллах ажлын цагийн нөхцөлийг уян хатан болгох талаар хэлтсийн дотоод журамд өөрчлөлт оруулах саналыг удирдлагад хүргүүлээд байна.		
10.4	№А/01	2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарлах тухай 2023.01.10 №А/01	Тус хэлтэс нь нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд нийгмийн даатгалд хэрхэн хамрагдах талаарх мэдээллийг хүргэж хууль тогтоомжийн талаарх мэдээллийг өгч ажиллалаа. Мөн татвар төлөгч аж ахуйн нэгжийн судалгааг авч шимтгэл төлөх талаарх заавар зөвлөмжийг бэлтгэн мэдээлэл зөвлөгөө өгсөн. Дээрх ажлын хүрээнд нийт 151 аж ахуйн нэгжийн удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна. 2023 онд нийт 135 ажил олгогчийн 378 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулж 10,9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлсэн.		

10.5.	№А/04	<p>2023 оны төсвийн хуваарь батлах тухай</p> <p>2023.01.10 №А/04</p>	<p>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар Мэргэжлийн хяналтын газарт нийгмийн хамгааллын улсын байцаагчаар ажиллаж байсан Г.Цэрэнжаргал нь тус хэлтсийн Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн нийгмийн хамгааллын улсын байцаагчийн албан тушаалд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажиллаж байна.</p> <p>2. Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын дагуу нийт 36 албан хаагчдад 554 026.4 мянган төгрөг,</p> <p>2. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” 491 дүгээр тогтоолын дагуу 81 140.2 мянган төгрөг,</p> <p>3. Засгийн газрын 489 дүгээр тогтоолоор Орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны 29 албан хаагчдад 20 хувиар 45 351.6 мянган төгрөг,</p> <p>4. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/73 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрэм”-д заасны дагуу мэргэшлийн зэрэг авсан 18 байцаагчдад үндсэн цалингийн 10 хувиар 29,511.6 мянган төгрөг,</p> <p>5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалыг үндэслэн аймгийн төвийн 24 албан хаагчдад нэг өдрийн 8.0 мянган төгрөгөөр, 12 сумдын байцаагч нарт нэг өдрийн 3.0 мянган төгрөгөөр тооцож нийт 44,513.7 мянган төгрөгийг олгосон байна.</p> <p>6. Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын дагуу нийт байцаагч, ажилтнуудад 56,687.3 мянган төгрөгийн урамшуулал олгоод байна.</p> <p>7. ЭХМК-ийн цагийн хөлсийг Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлж 13,0 мянган төгрөгөөр тооцож 31 059.2 мянган төгрөг зарцуулсан байна.</p> <p>8. “Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам”-д заасны дагуу Баян-Уул сумын байцаагчийн орон тоонд 2023 оны 5 дугаар сараас эхлэн “Хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,0 мянган төгрөгөөр ажиллуулж байна.</p> <p>7. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 13,671.8 мянган төгрөг батлагдсанаас 11,565.8 мянган төгрөг,</p>		
-------	-------	---	---	--	--

			<p>8. Хангамж бараа материалын зардалд 20,942.8 мянган төгрөгөөс 13,949.7 мянган төгрөг,</p> <p>9. Дотоод албан томилолтын зардал 7,787.1 мянган төгрөг батлагдсанаас 7, 179.6 мянган төгрөг,</p> <p>10. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 3 албан хаагчдын “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу шаардагдах зардлыг тооцон 2024 оны төсвийн төсөөлөлд тусган хүргүүлсэн.</p> <p>11. Ахмад настны тухай хуулийн дагуу хэлтсийн 21 ахмад настанд сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж бэлэг дурсгалын зүйлсэд 2,2681.5 мянган төгрөгийг зарцуулсан.</p> <p>12. Шилэн дансны мэдээллийн нэгдсэн системд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг pdf, хүснэгтэн хэлбэрээр өссөн дүнгээр сар бүр тогтмол хуулийн хугацаанд мэдээллийг байршуулан ажиллаж байна.</p>		
10.6	№А/07	<p>Төлөвлөгөө батлах тухай</p> <p>2023.01.18 №А/07</p>	<p>Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор 2023 оны 1 дүгээр сараас төсвийн байгууллагын гэрэл цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ нэмэгдсэнээр тус хэлтэст дулаан цахилгааны төлбөр тооцооны өглөг үүсэж төсөв хоорондын зохицуулалт хийх санал өгсний дагуу үйл ажиллагааны урсгал зардлын түлш халаалт, шуудан холбооны зардлын хуваарьт өөрчлөлт оруулсан. Дээрх өөрчлөлтөөр орсон төсвийн хуваарийн дагуу төлбөр тооцоог барагдуулсан болно.</p>		
10.7	№А/16	<p>Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай</p> <p>2023.01.24 №А/16</p>	<p>Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа 100 иргэнд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилготой "Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт" “Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ” сэдэвт сургалтыг 6 удаа зохион байгуулсан. -Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийг цахимаар авч, мэдээллийн баазтай тулган шалгаж шинээр 135 аж ахуй нэгж байгууллагыг бүртгэн, албан журмын даатгалд 385 даатгуулагчийг шинээр хамрууллаа. -Татварын байгууллагатай хамтран аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр ангилан 4 өдрийн сургалт зохион байгууллаа. <p>Сургалтад байгууллагын захирал, нягтлан бодогч, менежерүүд буюу нийт 80</p>		

			<p>төлөөлөгч оролцлоо. Сургалтад оролцогчдод нийгмийн даатгалын хууль тогтоомж, даатгуулагчийн төрөл шинээр нэмэгдсэн тухай, шимтгэл төлөлтөө цаг хугацаанд нь төлж өр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн болно</p> <p>Нийгмийн даатгалын байгууллага нь иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлэх үйлчилгээг цахимаар нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дорнод аймгийн нийгэм, улс төр мэдээллийг 7 хоног бүр нийтэлж хэвлэн гаргадаг “ДОРНОД” сонинд ажил олгогч байгууллагад хандан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг “Тоон гарын үсгээр” баталгаажуулан илгээх ач холбогдлын тухай мэдээллийн 4/1 булангаар хүргүүлж нийтлүүлсэн байна</p> <p>4Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,165,037.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн 180 байгууллагад шимтгэлийн авлага барагдуулах дараах ажлуудыг хуулийн дагуу хийж гүйцэтгэлээ.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> □ 197,361.4 мянган төгрөгийн урсгал авлага үүсгэсэн 51 аж ахуйн нэгж байгууллагын холбогдох албан тушаалтантай утсаар холбогдон 38 байгууллагын 52,680.6 мянган төгрөгийн шимтгэлийн авлага бүрэн барагдуулсан байна. □ 2022 оны жилийн эцсийн байдлаар 211,521.5 мянган төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэн 60 байгууллагад “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажилласан. Тус шаардлагын хуулийн хугацаанд 58 байгууллага 167,004.3 мянган төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулсан байна. □ Тухайн онд хуулийн дагуу арга хэмжээ авсан боловч шимтгэлийн өрийг хуулийн хугацаанд барагдуулаагүй 33 байгууллагын 176,491.6 төгрөгийн авлага барагдуулахаар Дорнод аймгийн сум дундын иргэний анхан шатны шүүхийн байгууллагад нэхэмжлэл хүргүүлсэн байна. <p>Шүүхэд нэхэмжлэл хүргүүлснээр 8 байгууллага 30,225.1 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай 15 байгууллагын 372,673.5 төгрөгийн авлага барагдуулахаар хамтран ажилласнаар 9 байгууллагын 143,239.1 мянган төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулсан байна.</p>		
--	--	--	---	--	--

			<p>Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэснээр шимтгэлийн авлага үүсгэсэн 180 байгууллагын 1,165,037.4 мянган төгрөгийн авлагаас нийт 153 байгууллагын 690,291.7 мянган төгрөг буюу 59.2 хувийн шимтгэлийн авлага барагдуулсан үзүүлэлтэй байна.</p> <p>Хуримтлагдсан авлага үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай уулзалт хийлээ.</p> <ul style="list-style-type: none"> - Айсвн ХХК 71,952,664.79 төгрөг - Онхоодой өндөр ХХК 19,222,461.04 төгрөг - Матад петротранс ХХК 32,344,683.8 төгрөг - Бронз стронг ХХК 55,099,250.35 төгрөг - Цагаан сор ХХК 30,696,705.76 төгрөг - Их базар ХХК 38,509,100 төгрөг - Ханшувалдай ХХК 21,492,340 төгрөг - Дөлгөөн ээж ХХК 8,560,000 төгрөгийн буюу нийт <p>277,877.2 мянган төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэн байна.</p> <p>Уулзалтаар хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж ажилласнаар эргэн төлөлтийн гэрээ байгуулан сар бүрийн төлөлтөд хяналт тавьж ажиллалаа. Эргэн төлөлтийн гэрээ байгуулсан 6 байгууллага нь гэрээний хугацаанд 147,302.8 мянган төгрөгийг шимтгэлийн авлага барагдуулсан байна.</p> <p>Гэрээний үүргээ биелүүлээгүй Ханшувалдай ХХК, Дөлгөөн ээж ХХК, Бронз стронг ХХК-ын шимтгэлийн өр барагдуулахаар шүүхийн байгууллагад баримт бичгийн бүрдүүлж, нэхэмжлэл хүргүүлэн ажиллалаа.</p>		
10.8	№А/31	<p>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p> <p>2023.03.14 №А/31</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/31 дүгээр тушаалаар баталсан 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар нийт 22 удаа хуралдаж 1407 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцэж шийдвэрлэв.</p>		

10.9	№А/36	Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай 2023.03.21 А/36	Уг тушаалаар баталсан даатгуулагчийн төрлийн “72”, “73” кодыг хуулийн хугацаанаас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.		
10.10	№А/39	Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023.03.27 №А/39	Тушаалын хэрэгжилтийг хангаж, албан тушаалын тодорхойлолтыг хэлтсийн даргын тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.		
10.11	№А/43	Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай 2023.04.07 №А/43	Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн “02”, “72”, “73” код шинээр, “06”, “32” кодын нэрийг өөрчилсөн тул холбогдох журам, тушаалын хэрэгжүүлэхээр холбогдох албан тушаалтанд мэдээлэл хүргүүлэн ажилласан. Ажил олгогчтой Иргэний хуулийн 343,359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу буюу “02” кодтой 55 даатгуулагч, “32” кодтой 1 даатгуулагч, “06” кодтой 878 даатгуулагч тус тус бүртгэгдсэн ба “72”, “73”, кодтой даатгуулагч бүртгэгдээгүй байна. Иргэний хуулийн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч даатгуулагчийн “02” төрөл шинээр нэмэгдсэнээр энэ төрлийн даатгуулагчийн шимтгэлийг “40” кодоор буюу шимтгэлийг дутуу тайлагнахаас урьдчилан сэргийлж чадсан байна		
10.12	А/47	Сургалт зохион байгуулах тухай 2023.0.07 №А/47	Тус албан бичгийн дагуу НДЕГ-аас зохион байгуулсан сургалт, хэлтсийн болон аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан сургалтад тухай бүр Архив, хөрөнгө хариуцсан ажилтан хамрагдаж байна.		
10.13	А/49	2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2023.04.17 №49	Байгууллагын батлагдсан төсвийн үйл ажиллагааны урсгал зардлын түлш халаалт, шуудан холбооны зардлын хуваарьт өөрчлөлт оруулснаар: - Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор 2023 оны 1 дүгээр сараас төсвийн байгууллагын гэрэл цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ нэмэгдсэнээр тус хэлтэст өглөг үүссэн төлбөрийг барагдуулсан.		

			- “Монголын цахилгаан холбоо”-ны “call center” үйлчилгээг 2023 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэнээр сар бүр тогтмол 245,0 мянган төгрөгийн төлбөрийг төлж өглөг үүсгэхгүйгээр ажиллаж байна.		
10.14	A/56	Аймаг, дүүргүүдэд зохион байгуулах сургалтын төсвийн хуваарь батлах тухай 2023.04.18 №A/56	“Аюулгүй байдал нэн тэргүүнд” ТББ сургалтын төв нь Дорнод аймгийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран 2023 оны 09 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Дорнод аймгийн Жижиг дунд бизнесийг дэмжих төвийн сургалтын танхимд тус аймгийн 20 гаруй аж ахуйн нэгж байгууллагын нийт ажилчдын төлөөлөлд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, МШӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийг сургалтын инженер Л.Ургамал, ХАБ-ын багш Г.Намуун-Эрдэнэ, үйл ажиллагааны менежер Г.Баттулга нар лекц, дадлага хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд нийт 20 байгууллага аж ахуйн нэгжийн 50 ажилчид хамрагдсан. Сургалтад оролцсон нийт хүмүүсээс заасан хичээлээр тест бэлтгэн шалгалт авсан. Мөн сургалтын төгсгөлд модуль тус бүрд багшийг үнэлэх хуудсаар үнэлгээ авсан. “Аюулгүй байдал нэн тэргүүнд” ТББ сургалтын төв нь ажил гүйцэтгэх гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн гэж дүгнэв.		
10.15	A/80	Урамшуулал олгох тухай 2023.05.25 A/80	Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд, үнэн зөв, чанартай гаргаж, аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан санхүү, бүртгэлийн ажилтнуудад 1,610.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.		
10.16	A/86	Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай 2023.06.06 A/86	Нийгмийн даатгалын 2022 оны нэгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Тус хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Батбаярт 2022 онд албан томилолтыг олгоходоо 56,400 төгрөг илүү олгосныг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Татварын хэлтсийн 100070000952 тоот дансанд төвлөрүүлж, төлбөрийг барагдуулсан актын биелэлтийг Төрийн аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Санхүү бүртгэлийн газарт цаг хугацаанд нь хүргүүлсэн		
	A/92	Журам шинэчлэн батлах тухай	Хэлтсийн даргын тушаалаар томилогдсон тооллогын комиссын бүрэлдэхүүн байгууллагын эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материал, маягт үнэт		

		2023.06.14 A/92	<p>цаасны тооллогыг тогтоосон хугацаанд зохион байгуулж тайланг Санхүү бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн 9 нэр төрлийн 341,926.8 мянган төгрөг, • Авто тээврийн хэрэгсэл 1 ширхэг 69,800.0 мянган төгрөг, • Машин тоног төхөөрөмж 47 нэр төрлийн 137,506.9 мянган төгрөг, • Тавилга эд хогшил 45 нэр төрлийн 56,734.2 мянган төгрөг, • Биет бус хөрөнгө 5 ширхэг 3,103.3 мянган төгрөг, • Газар 44,000.0 мянган төгрөг нийт 653,071.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байцаагч, ажилтнуудын эд хөрөнгийн бүртгэлийн карттай тулгалт хийн хөрөнгүүдийг тоолсон. <p>ТӨБЗГ-ын 2023 оны 122 дугаар тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын газрын хөрөнгөд бүртгэлтэй 3 нэр төрлийн 3,055.0 мянган төгрөгийн үнэтэй /нөөтбүүк, компьютер, принтер/ 2,128.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 926.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж, 215.0 мянган төгрөгийн үнэтэй ширээг тус тус санхүүгийн программд балансаас шилжиж ирсэн хөрөнгөөр бүртгэсэн.</p> <p>НДЕГ-ын даргын 2023 оны тушаалын дагуу тус хэлтэст бүртгэлтэй 386 ширхэг нийгмийн даатгалын дэвтэр, 260 ширхэг эрүүл мэндийн гэрчилгээний анхан шатны маягыг данс бүртгэлээс хассан байна.</p> <p>ӨХБЗ-ийн гишүүдийн хурлын шийдвэрээр 2023 онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй, цаашид ашиглах боломжгүй болсон нийт 7 нэр төрлийн 11,142.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хөрөнгийг актлах саналыг НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт, 69,800.0 мянган төгрөгийн үнэтэй форд эверэст маркийн автомашины үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлээд байна.</p>		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					
11. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар					
11.1	№01	Ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний тухай	Төрийн албаны болон нийгмийн даатгалын ажилтны ес зүй сахилга батыг чанд сахиж ажлын хариуцлага, цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах, ажлын байрны стандарт, дэг журмыг мөрдөн ажиллах талаар албан даалгаврыг нийт ажилтнуудад танилцууллаа. Мөн нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар хандсан ажил олгогч даатгуулагч тэтгэвэр авагчдад үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэхэд анхаарч байцаагч ажиллаж байна.		

		2022.01.25 №01	Ажилтнуудын харилцаа хандлагыг төлөвшүүлэх сургалтыг тогтмолжуулснаар 2023 онд иргэд даатгуулагчаас ёс зүйн талаар зөрчил гомдол гаргаагүй байна. Хэлтсийн дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж ёс зүй, харилцаа хандлагын үзүүлэлтийг үр дүнгийн гэрээнд тусган тооцож ажиллаж байна. Албан даалгаврын биелэлтийг улирал дүгнэн хэлтсийн даргын зөвлөлд танилцуулан НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.		
11.2	№02	Ажил эрчимжүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.12.14 №02	Байцаагч ажилтнууд нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах журам”-ыг баримтлан ажлын цаг ашиглалтыг сайжруулж, харилцаа хандлагадаа анхаарч ажиллаж байна. “Нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт”-д нийцүүлэн ажлын байрны тохь тух даатгуулагчдад үйлчлүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажлын байрны дуу чимээ, агаар сэлгэлт, гэрэлтүүлэг зэргийг мэргэжлийн байгууллагаар судлуулан дүгнэлт гаргуулсан. Ажлын гүйцэтгэлд хяналт тавин хугацаатай албан бичгийн хариуг Иргэд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд нягтлан шалгаж шийдвэрлэх ажлын хэсгийг байгуулан шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.		
<i>Хэрэгжилт: 100 хувь</i>					
Нийт хэрэгжилтийн хувь: 100 хувь					

Биелэлтийг нэгтгэж боловсруулсан:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Б.ОТГОНЦЭЦЭГ

Хянаж танилцсан:

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.АРИУНБОЛД

2023 оны 12 дугаар сарын 05